

## 2.2.1. Баталгаажуулах хүсэлт

Цэцэрлэг дээр шинэ суралцагч бүртгэх үед тухайн суралцагчийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдах нас бага эсвэл их үед аймаг, нийслэлийн БСУГ -ын холбогдох мэргэжилтнээр заавал баталгаажилт хийлгэх шаардлагатай. Боловсролын удирдлага системийн **Суралцагч** модульд суралцагчийг нэмэх үед **Хянагдаж байгаа** төлөвтэйгээр суралцагч бүртгэгддэг.

Суралцагч

№	Хичээлийн жил	Суралцагч	Регистр	Хүйс	Анги	Бүлэг	Хөтөлбөр	Сургалтын хэлбэр	Сургалтын ачаалал	Төлөв	Батлагдсан эсэх
86	2022-23 Хичээл...	М.Оюунгоо	ул18291983	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
87	2022-23 Хичээл...	С.Сарантуяа	фа18261929	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
88	2022-23 Хичээл...	М.Саруул	ya18262321	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
89	2022-23 Хичээл...	У.Сувдансондор	ух18220701	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
90	2022-23 Хичээл...	Б.Удвал	ук19231764	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
91	2022-23 Хичээл...	Б.Энгүүн Зои	ук18290267	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
92	2022-23 Хичээл...	С.Юүбийн	рo18283149	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
93	2022-23 Хичээл...	Э.Ужингоо	ya18210968	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
94	2022-23 Хичээл...	Б.Амингоо	ya18322341	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
95	2022-23 Хичээл...	Т.Сийлэн	ул18210507	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
96	2022-23 Хичээл...	Б.Ариунцацрал	ya19211105	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
97	2022-23 Хичээл...	Б.Нинжин	yy18232743	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
98	2022-23 Хичээл...	Б.Гүндарь	yp18320362	Эмэгтэй	Ахлах	хичээнгү...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
99	2022-23 Хичээл...	Г.Удвал	ya16312622	Эмэгтэй	Бэлтгэл	дарууха...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Хянагдаж байгаа
100	2022-23 Хичээл...	Б.Эгциглэн	ya17282463	Эмэгтэй	Бэлтгэл	дарууха...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
101	2022-23 Хичээл...	Х.Содон-Од	ум17300202	Эмэгтэй	Бэлтгэл	дарууха...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан
102	2022-23 Хичээл...	Б.Гэгээн-Үйлст	ул18220248	Эмэгтэй	Бэлтгэл	дарууха...	СӨБ - Сургуулийн өмнөх боловсролын ...	Үндсэн	Бүтэн цаг	Идэвхтэй	Батлагдсан

Хуудас 6 - 7 (115 бичлэгээс 86 - 102)

Хянагдаж байгаа төлөвтэй суралцагчийн баталгаажуулах хүсэлтийн явцыг **Баталгаажуулах хүсэлт** модулиар шалгана. Цэцэрлэгээс харьяалагдах Аймаг, нийслэлийн боловсрол газарт илгээсэн суралцагчийн бүртгэлтэй холбоотой баталгаажуулах хүсэлтүүд аль түвшинд ямар явцтай байгааг энэ цонхноос харах боломжтой.

1. **Хичээлийн жил** -ийг энэ хэсгээс сонгоно. Өмнөх хичээлийн жилийн мэдээллийг түүх байдлаар харах боломжтой.
2. **Хүсэлтийн төрөл** хэсгээс “Шинэ суралцагч нэмсэн”, “Хөтөлбөр хооронд шилжсэн”, “Экстранат” төрлүүдээр шүүлт хийж болно.
3. **Хүсэлтийн төлөв** хэсгээс “Хянагдаж байгаа”, “Батлагдсан”, “Цуцлагдсан” сонголтууд хийж 5-р хэсгийн жагсаалтыг өөрчилж болно.
4. **Хайлт** хэсэгт суралцагчийн нэр эсвэл регистрийн дугаарыг оруулж баталгаажуулах хүсэлтийн жагсаалтаас хайлт хийх боломжтой.
5. Баталгаажуулах хүсэлтийн **жагсаалт**
6. Тухайн сонгогдсон баталгаажуулах хүсэлтийн **дэлгэрэнгүй мэдээлэл**
  - Хүсэлт илгээсэн сургууль
  - Суралцагчийн мэдээлэл
  - Хөтөлбөр төлөвлөгөөний мэдээлэл
  - Баталгаажуулалтын явц
  - Аль түвшинд ямар явцтай байгааг харуулна.
  - Суралцагчийн суралцсан түүх

## 2.2.2. Шилжилт хөдөлгөөн

Суралцагч хасуулах хүсэлтийг цэцэрлэг хооронд илгээдэг бөгөөд шилжилт хөдөлгөөний хэдэн хүсэлт хянагдаж байгааг жагсаалтаар харуулна.

1. **Хичээлийн жил** -ийг энэ хэсгээс сонгоно. Өмнөх хичээлийн жилийн мэдээллийг түүх байдлаар харах боломжтой.
2. **Хүсэлтийн төрөл** сонголтоос нийт хүсэлтийг бүлэглэн харна.
  - *Ирсэн хүсэлт* – Манай цэцэрлэг дээр хянагдаж байгаа бусад цэцэрлэгээс ирсэн суралцагч

хасуулах хүсэлтүүд

- *Илгээсэн хүсэлт* – Манай цэцэрлэгээс бусад цэцэрлэгт суралцагч хасуулахаар илгээсэн хүсэлтүүд

3. **Хүсэлтийн төлөв** хэсгээс “Хянагдаж байгаа”, “Батлагдсан”, “Цуцлагдсан” сонголтууд хийж 5-р хэсгийн жагсаалтыг өөрчилж болно.

4. **Хайлт** хэсэгт суралцагчийн нэр эсвэл регистрийн дугаарыг оруулж хасуулах хүсэлтийн жагсаалтаас хайлт хийх боломжтой.

5. Хасуулах хүсэлтийн **жагсаалт**

6. Тухайн сонгогдсон хасуулах хүсэлтийн **дэлгэрэнгүй мэдээлэл**

- Хүсэлт илгээсэн цэцэрлэг/Хүсэлт хүлээн авсан цэцэрлэг
- Одоо сурч буй цэцэрлэг, суралцагчийн мэдээлэл
- Баталгаажуулалтын явц
- Суралцагчийн суралцсан түүх

7. Тухайн хүсэлтийг сонгож Баталгаажуулах эсвэл Цуцлах үйлдлийг хийж болно.

- Баталгаажуулах үйлдэл хийгдсэнээр тухайн суралцагч манай цэцэрлэгээс хасагдаж хүсэлт нь “Батлагдсан” төлөвт шилжинэ.
- Тухайн хүсэлтийг буруу эсвэл зөвшөөрөхгүй гэж үзвэл Цуцлах үйлдэл хийж хүсэлтийг “Цуцлагдсан” төлөвт шилжүүлнэ.

**Баталгаажуулах** товч дарахад хяналтын нэмэлт цонх гарч ирэх бөгөөд үйлдлийн шалтгаан болон тайлбар нь автоматаар бөглөгдсөн байна. Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг баталгаажуулж “Тийм” товч дээр дарж суралцагчийг цэцэрлэгээс шууд хасна. Баталгаажуулсан шилжилт хөдөлгөөний бүртгэл нь “Батлагдсан” төлөвт шилжинэ.

---